



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/19

Онги

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 120 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Мал эмнэлэг үржлийн тасгийн мал зүйч

Хүнс, Жижиг дунд үйлдвэр, Хоршоо хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Хэсгийн төлөөлөгч

2.Сумын иргэдийн дунд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг тогтмол явуулж байхыг зөвлөлд даалгасугай.

3.Ажлын төлөвлөгөө, шийдвэр, шийдвэрийн гүйцэтгэлийг улирал бүр Засаг даргын зөвлөлд мэдээлж тайлагнаж байхыг зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/48 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА

D disk /2024on/A Zahiramj.doc

482/01019x

